



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.09 № 54

Хуулийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. ..." гэж, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн "эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" гэж тус тус заасан байдаг.

"Оюу толгой төсөл"-ийн үйл ажиллагаа говийн бүсийн экосистемд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, хууль тогтоомжийн зөрчлийн талаар иргэд, олон нийтээс Улсын Их Хурлын гишүүнд хандан байнга гомдол, шаардлага ирүүлсээр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

1. "Оюу толгой" ХХК нь байгаль орчныг хамгаалах менежментийн 2025, 2026 оны төлөвлөгөөгөө батлуулахгүйгээр олборлолт явуулсан гэх мэдээлэл үнэн эсэх;

2. Дээрх мэдээлэл үнэн бол батлагдаагүй төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн үйл ажиллагааг нь зогсоох зэргээр холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байгууллага, албан тушаалтны талаарх мэдээлэл;

3. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцсон эсэх, тооцоогүй бол хэзээ, хэрхэн хариуцлага тооцох, зөрчлийг арилгах арга хэмжээний талаарх мэдээлэл.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд асуултын хариуг ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

О.АЛТАНГЭРЭЛ

2026000158